2109	Бараа үйлчилгээний бусад зардал	285,292,700.00	285,084,238.94	268,692,966.94	-10,714,375.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	247,233,800.00	247,025,339.00	247,025,339.00	-27,866,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	38,058,900.00	38,058,899.94	38,058,899.94	761,253.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	190,496,000.00	183,186,750.00	183,186,750.00	0
2132	Бусад урсгал шилжүүлэг	190,496,000.00	183,186,750.00	183,186,750.00	0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	27,299,800.00	26,600,000.00	26,600,000.00	0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	143,035,300.00	136,435,000.00	136,435,000.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,160,900.00	20,151,750.00	20,151,750.00	0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	649,743,700.00	541,789,146.00	541,789,146.00	0
223001	Бусад хөрөнгө	649,743,700.00	541,789,146.00	541,789,146.00	0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	739,160,000.00	516,807,470.00	0	516,807,470.00
230001	Эргэж төлөгдөх зээл	739,160,000.00	516,807,470.00	516,807,470.00	0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,774,457,600.00	9,442,235,551.26	9,018,564,849.00	277,836,689.26
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,375,176,200.00	5,376,534,200.00	8,019,849,800.00	-2,820,270,362.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	0	0	2,643,315,600.00	-2,621,147,600.00
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	5,375,176,200.00	5,376,534,200.00	5,376,534,200.00	-199,122,762.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,951,420,700.00	3,352,828,826.70	308,128,100.00	3,069,224,477.70

Хархорин сумын төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	308,125,100.00	308,125,100.00	308,125,100.00	0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,447,860,700.00	713,072,522.56	690,589,949.00	28,882,573.56
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	583,630,100.00	695,515,384.56	695,515,384.56	0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,250,000.00	17,557,138.00	22,157,138.00	-4,600,000.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	849,980,600.00	0	862,017,841.60	-85,617,841.60
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	367,938,730.60	0	367,938,730.60
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	451,393,067.16	0	451,393,067.16
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	4,198.00	4,204.00	0	4,000.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	15	15	0	14
610001	Төсвийн байгууллага	14	14	0	13
610002	Төсвөөс гадуур байгууллага	1	1	0	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	378	381	0	366
620001	Удирдах ажилтан	24	24	0	23
620002	Гүйцэтгэх ажилтан	240	241	0	233
620003	Үйлчлэх ажилтан	108	110	0	104
620004	Гэрээт ажилтан	6	6	0	6
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	3,427.00	3,427.00	0	3,254.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	2,565.00	2,565.00	0	2,565.00
630001	Төрийн өмчит ЕБС	2,565.00	2,565.00	0	2,565.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	862	862	0	689
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	862	862	0	689
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	378	381	0	366
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	12	12	0	12
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	14	14	0	14
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	10	12	0	12
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	328	329	0	314
650010	Гэрээт ажилтан	3	3	0	3
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	11	11	0	11

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	428,749,031.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	428,749,031.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	347,211,716.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,354,565.00
210101	Үндсэн цалин	6,354,565.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	976,780.00
210201	Тэтгэврийн даатгал	976,780.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,128,944.00
210301	Гэрэл, цахилгаан	1,500,000.00
210302	Түлш халаалт	6,128,944.00
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,963,695.00
210401	Бичиг хэрэг	1,226,207.00
210402	Тээвэр, шатахуун	3,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	870,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	987,097.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	680,391.00
2105	Нормативт зардал	7,242,717.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,706,717.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,536,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	70,091,513.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,400,000.00
210604	Урсгал засвар	64,691,513.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	119,234,932.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	111,985,512.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	108,000.00
210807	Газрын төлбөр	7,141,420.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	126,216,570.00

Хархорин сумын төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	125,457,317.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	761,253.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,537,315.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,859,140.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,859,140.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	57,678,175.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас	57,678,175.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	428,749,031.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	428,749,031.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,853,900.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	233,114,814.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	110,110,527.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	83,669,790.00

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хархорин сумын Төрийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2022.03.20-ноос 2022.03.24-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.03.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.03.21-ний өдрийн 02/61 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

Сумын төрийн сангийн нэгтгэсэн тайланд 16 төсөвт байгууллага, 3 сан, 1 ерөнхий орлогын данс нийт 20 тайлан нэгтгэгджээ.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.”Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно.” гэж заасан.

Мөн хуулийн 36.1.”Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид “төрийн сан” гэх/-оос бүрдэнэ.

36.2.Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна.

36.3.Сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон төсвийн хэмжээг нь харгалзан төрөлжүүлж, тэдгээрт хамаарах

төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн алба байгуулж болно.” гэсэн заалтуудаар зохицуулагдаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хархорин сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хархорин сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 13 тэрбум 697.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 136.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 102.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 253.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хархорин сумын төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	872.5	1125.6	253.1
31211	Төрийн сангийн харилцах	832.5	1104.1	271.6
31213	Арилжааны банк дахь харилцах	40	21.5	-18.5

Дараах байгууллагуудын данс мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Сая төгрөг

Орон нутгийн ерөнхий орлого	674.3
Эрсдэлээс хамгаалах сан	9.8
Сум хөгжүүлэх сан	346.1
ОНХСан	73.9
Энэрэл Хархорин ӨЭМТ	21.5

Created with Datawrapper

3.5.2 Авлага

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Эзлэх хувь
33	АВЛАГА	1120.2	987.6	-132.6	100
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1.8	0.3	-1.5	0.03
33300	Татаас, санхүүжилтийн авлага			0	0.00
33400	Зээлийн хүүгийн авлага	43.3	32.3	-11	3.27
3351	Байгууллагаас авах авлага	27.8	0.8	-27	0.08
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1047.3	954.2	-93.1	96.62

Тайлант оны нийт авлагын 96.6 хувийг хүмүүсээс авах авлага эзэлж байна.

Хувь хүмүүсээс авах авлагын 915.9 сая төгрөг нь СХСангаас олгосон зээлийн авлага, 38.3 сая төгрөг нь эрсдэлээс хамгаалах сангаас малчдад олгосон өвс тэжээлийн авлага, 0.7 сая төгрөг нь Өрхийн ЭМТөвийн авлага байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 44.6 сая төгрөгөөр өссөн байна.

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Эзлэх хувь
35	БАРАА МАТЕРИАЛ	604.8	649.4	44.6	100
351	Түүхий эд материал	202.2	236.2	34	36.4
354	Хангамжийн материал	365.9	376.4	10.5	58.0
35600	Мал амьтад	36.7	36.7	0	5.7
36	НӨӨЦИЙН БАРАА	31.2	36.3	5.1	

Тайлант онд бараа материалын үлдэгдэл ЭМТөвд 44.6 сая төгрөгөөр өссөн нь ковидын эмчилгээ үйлчилгээтэй холбоотой эм боох материал, бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэн байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 3 тэрбум 161.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хархорин сумын төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Код	Үзүүлэлт	Хөрөнгийн дүн
1	Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	54,856.40
2	Нэмэгдсэн	5,600.60
201	Худалдан авсан	485.80
202	Хандиваар	2,839.30
203	Шилжүүлэн авсан	2,153.60
205	Бусад	121.90
206	Дахин үнэлгээний нэмэгдэл	
3	Хасагдсан	2,439.10
302	Акталсан	184.50
303	Шилжүүлсэн	2,178.90
305	Бусад	75.60
4	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	58,017.90

Хархорин сумын Төрийн сангийн үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн нэгтгэлээр 5 тэрбум 600.6 сая төгрөгийн хөрөнгө шинээр бүртгэлд тусгаснаас 485.8 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 5 тэрбум 114.8 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэлд тусгажээ. Харин 184.5 сая төгрөгийн хөрөнгийг акталсан, 2 тэрбум 178.9 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн, 75.6 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлэхээр данснаас хассан байна.

Тайлант онд сумын хэмжээнд Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2 тэрбум 635.7 сая төгрөгийн барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулсан, 1 тэрбум 711.0 сая төгрөгийн барилга байгууламжийг шилжүүлэн авсан, 83.4 сая төгрөгөөр тээврийн хэрэгсэл, 345.8 сая төгрөгөөр машин тоног төхөөрөмж, 125.5 сая төгрөгөөр тавилга эд хогшил, 7.2 сая төгрөгөөр түүх соёлын дурсгалт зүйл, 19.7 сая төгрөгөөр ном, 12.5 сая төгрөгөөр программ хангамж, 393.5 сая төгрөгөөр бусад биет бус хөрөнгийг тус тус бэлтгэсэн байна.

3.5.5 Өр төлбөр

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Эзлэх хувь
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2.7	73.3	70.6	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2.7	73.3	70.6	100
41320	Бараа үйлчилгээний өглөг	0	4.4	4.4	6.0
41361	Байгууллагад төлөх өглөг	0.9		-0.9	0.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1.7	69	67.3	94.1

Тайлант онд өр төлбөр 70.6 сая төгрөгөөр өссөн нь ОНХСангийн санхүүжилтийн дутуу 68.9 сая төгрөгийг өглөгөөр бүртгэсэнтэй холбоотой байна. Мөн 2 дугаар сургууль 0.7 сая төгрөг, 4 дүгээр сургууль 3.7 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

3.6.1 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын ИТХ-ын 2020 оны 3/06 тоот тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг 667.3 сая төгрөгөөр баталжээ. Гүйцэтгэлээр 1 тэрбум 237.1 сая төгрөгийн орлого төвлөрч, орлогын төлөвлөгөө 569.8 сая төгрөг буюу 85.4 хувиар давж биелжээ. Энэ нь төлөвлөгдөөгүй малд ногдуулах албан татвар, ан амьтны нөөц ашигласны татварын орлого 237.4 сая төгрөг орсон, мөн хүү торгуулийн орлого 254.2 сая төгрөгөөр илүү төвлөрсөнтэй холбоотой байна.

Төлөвлөгдсөн татварын орлогуудаас Улсын тэмдэгтийн хураамж, газрын төлбөр, хог хаягдлын хураамжийн орлого 2.2-40.5 хүртэл хувиар тасарсан байна.

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	45,000	80,865	35,865	179.7
2	Хөрөнгийн орлого	205,100	211,465	6,365	103.1
3	Хөрөнгө борлуулсны орлого	10,000	66,793	56,793	667.9
4	Бууны албан татвар	3,495	3,506	11	100.3
5	Улсын тэмдэгтийн хураамж	46,985	27,972	(19,013)	59.5
6	Түгээмэл тархацтай АМНАТ	1,000	19,416	18,416	1941.6
7	Хог хаягдлын хураамж	60,000	58,662	(1,338)	97.8
8	Газрын төлбөр	68,227	48,070	(20,158)	70.5
9	Ус рашааны нөөц			-	
10	Ан амьтны нөөц ашигласны төлбөр		109,210	109,210	
11	Малд ногдуулах албан татвар		128,190	128,190	
12	Ойн төлбөр	2,500	3,791	1,291	151.6
	Татварын орлого	442,307	757,938	315,631	171.4
1	Татварын бус/ Хүү, торгуулийн орлого	225,000	479,174	254,174	213.0
	Нийт дүн орлого	667,307	1,237,112	569,805	185.4

3.6.2 Орон нутгийн төлөвлөлт, гүйцэтгэл

2021 онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр 9 тэрбум 774.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 5 тэрбум 375.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 2 тэрбум 951.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1 тэрбум 447.9 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5 тэрбум 376.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 3 тэрбум 352.6 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 713.1 сая төгрөг, нийт 9 тэрбум 442.2 сая төгрөгийн санхүүжилт, болон орлогын эх үүсвэр бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 8 тэрбум 64.2 сая төгрөг, хөрөнгийн зардалд 541.8 сая төгрөг, эргэн төлөгдөх зээлд 516.8 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 183.2 сая төгрөгийг зарцуулж, нийт 9 тэрбум 306.0 сая төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар сумын хэмжээнд 428.7 сая төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний зардалд 347.2 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 81.5 сая төгрөг зарцуулжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах зүйл байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 2 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хархорин сумын Төрийн сан нь 2021 онд 155 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 154 мэдээллийг ил тод мэдээлсэн, 1 мэдээллийн хугацаа болоогүй байна. 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар алдаа зөрчил илрээгүй.

3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол

Төлөвлөлтийн шатанд 5.0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн. Аудитаар тооцож бүртгэсэн үр өгөөж байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Хархорин сумын Төрийн сангийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй.

4.1 Харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийн талаар

Аудитад хамрагдсан 17 байгууллагаас 8 байгууллагад дүгнэлт гаргаж 9 байгууллагыг түүвэрт хамруулсан. / Зөрчилгүй 7 дүгнэлт, Хязгаарлалттай 1 дүгнэлт/

Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэлээр **794.9** сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 679.2 сая төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 115.6 сая төгрөгийн зөрчилд 115.0 сая төгрөгийн 11 албан шаардлага, 0.7 сая төгрөгийн 16 зөвлөмжийг хүргүүлсэн.

-ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчиж Эрдэнэзуу музей 8.9 сая төгрөг, ЗДТГазар 7.4 сая төгрөг, Соёлын төв 1.7 сая төгрөг, ИТХ 1.5 сая төгрөг, нийт **19.6 сая төгрөгийн** худалдаг авалт хийсэн

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт **680.4** сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн. Үүнд:

ЗДТГазарт- Санхүүгийн тайлангийн уялдаа үндсэн хөрөнгийн үнэ төлбөргүй орлого үр дүнгийн тайланд 1300.0 мянган төгрөгөөр илүү тайлагнагдсанаас зөрсөн, Улаан буудайн үр болох 23410.0 мянган төгрөгийн нөөцийн барааг хүнсний материалд бүртгэсэн, Соёлын төвийн өмнөх элэгдлээрээ өртгөө нөхсөн 13679.7 мянган төгрөгийн талбай болох барилга байгууламжийг шилжүүлэн бүртгэж орлого авахдаа биет бус хөрөнгөнд бүртгэснийг залруулсан, 6114.4 мянган төгрөгийн программ хангамж ашигладаг боловч бусад биет бус хөрөнгөнд бүртгэсэн, Аймгийн ИТХ-ын 2021 оны 4 сарын 26-ны өдрийн 32 тоот тогтоолоор Хархорин сумын сумын Соёлын төвийн хөрөнгөнд бүртгэлтэй 112000 мянган төгрөгийн газрыг ЗДТГ-т шилжүүлсэн шийдвэр гарсан боловч бүртгээгүй байна.

3 дугаар сургуульд- Үндсэн хөрөнгийн үнэ төлбөргүй авсан орлогыг үр дүнгийн тайланд 4642.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнаснаас санхүүгийн тайлангийн уялдаа зөрсөн, балансын дахин үнэлгээний нэмэгдэл эхний үлдэгдэл 5945.5 мянган төгрөгийг өмнөх оны үр дүнд оруулан тайлагнасан, бараа материалын үнэ төлбөргүй орлогыг үр дүнгийн тайланд 5110.5 мянган төгрөг дутуу тайлагнаснаас тайлант оны үр дүн буруу илэрхийлэгдсэн байна.

СХСанд- Тайлант онд 506977.0 мянган төгрөгийн зээл олгосон боловч авлагын тодруулга тайланд тайлагнаагүй

2 дугаар цэцэрлэгт- Цэлингийн цэс дээрх дүнгүүд программ дээрх дүнтэй таарахгүй зөрүүтэй, байгууллагын нягтлан бодох бүртгэлд ашиглаж буй санхүүгийн программ нь санхүүгийн тайлан, мэдээ, маягтыг иж бүрэн боловсруулан гаргахад учир дутагдалтай, өмнөх оны дүнг санхүүгийн тайланд зэрэгцүүлээгүй байна.

1 дүгээр цэцэрлэгт- Хүнсний тайлангийн анхан шатны баримт дээр засвар хийсэн, үнийн дүнг зөрүүлж бичсэн

Номын хүрдэн сургуульд- Жирэмсний болон амаржсаны амралттай албан хаагчийг 01 кодоор буруу тайлагнасан

- **Дотоод хяналт хариуцлагатай холбоотой 37.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн.**

3 дугаар сургуульд - Санхүүгийн тайлангаар жилийн эцэст 1265.8 мянган төгрөгийн бичиг хэрэг, 1071.6 мянган төгрөгийн эм, 1265.5 мянган төгрөгийн хоолны материалын үлдэгдэлтэй боловч тоолоогүй

СХСанд-Гүн уужим ХХК -нд 2021.02.09-нд 30000.0 мянган төгрөгийн зээл, иргэн Э.Сүрэнхорлоод 2021.07.26-нд 3000.0 мянган төгрөгийн зээлийг барьцаа хөрөнгө өөр хүний нэрээр, итгэмжлэлгүй олгосон.

Өрхийн эмнэлэгт- Өмнөх онуудад үүссэн 672,8 мянган төгрөгийн авлага барагдаагүй байна, Тус байгууллага нь өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон дотоод хяналт шалгалтын журам боловсруулж мөрдөөгүй байна.

- **Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчил илэрсэн.**

ОНХСанд- Ажил гүйцэтгэгч талтай шууд гэрээ байгуулахдаа ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаагүй

2 дугаар цэцэрлэгт- Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2014 онд хийгдсэн, шинэчлээгүй

1 дүгээр цэцэрлэгт- Хүнс нийлүүлэгч гэрээтэй харилцагч байгууллагууд гэрээнд тусгасан үнийн саналаас илүү үнээр хүнс нийлүүлсэн. Үнийн өөрчлөлт гарч болох талаар заалт гэрээнд тусгаж өгөөгүй, харилцагч байгууллагуудтай гэрээ байгуулахдаа ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаагүй байна

- Нийцлийн аудитаар илэрсэн зөрчил

2 дугаар цэцэрлэгт- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй

Өрхийн эмнэлэгт- Шилэн дансны цахим хуудсанд нэвтэрч оруулах ёстой мэдээллийг бүрэн оруулсан эсэхийг шалгахад нийт 119 мэдээлэл оруулахаас 8 мэдээллийг хугацаа хожимдуулан оруулсан

1 дүгээр цэцэрлэгт- Шилэн дансны цахим хуудаст нийт 13 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан

Спортын ордон-Шилэн дансны хуульд заасан хугацаанд мэдээллийг оруулаагүй хугацаа хоцроосон

Орхон сургууль- Шилэн дансанд Нийт 149 мэдээлэл оруулахаас 17 мэдээг хугацаа хоцроосон байна.

- Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой **5.0** сая төгрөгийн зөрчил илэрсэн.

5 дугаар цэцэрлэгт- Хүүхдийн хоолны зардлын хэмнэлтээс 2800.0 мянган төгрөгийн мах нөөцөлсөн.

4 дүгээр цэцэрлэгт- Хүнсний материалын үлдэгдэл их байхад оны эцэст 2245.1 мянган төгрөгийн хүнсний материал дахин бэлтгэж нөөцөлсөн

- Худалдан авалттай холбоотой **52.6** сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Номын хүрдэн сургууль- Шинээр нийт 62545.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан бөгөөд үүний 52575.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөд худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Хархорин сумын Төрийн сан	0	0	0	00	0	0	0	0	0	0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР